

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮНИЙ ГОЦ ХАЛДВАРТ, ЗООНОЗЫН ӨВЧНИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ, БИОЛОГИЙН АЮУЛЫН ҮНЭЛГЭЭ

Г. Ганзориг

*ДХИС-ийн Ахисан шатны боловсролын сургуулийн магистрант, ахлах
дэслэгч*

Цахим шуудан: ganzorignema@gmail.com

Түлхүүр үгс: биологийн аюул, зоонозын халдварт өвчин, өвчний тохиолдол, боом, галзуу өвчин, тарваган тахал, хачигт халдвар,

Оршил

Уур амьсгалын өөрчлөлт, хүн амзүйн болон эдийн засгийн нөхцөл байдлаас Хөвсгөл аймагт тохиолдох биологийн аюулын тохиолдол, давтамж буурахгүй учруулах хохирол нэмэгдэх хандлагатай байна. Аймгийн хэмжээнд тохиолдож буй зоонозын халдварт өвчнүүд, хүний өвчлөлийн төлөв байдал, байгалийн голомт, хүн амд учрах эрсдэлийг үнэлэх улмаар сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох нь гамшгаас хамгаалах албад мэргэжлийн ангиудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

Суурь нөхцөл байдал

Хөвсгөл аймаг нь Булган, Архангай, Завхан аймагтай, улсын хилээр зааглагдаж ОХУ-ын Тува, Буриад улсуудтай хиллэдэг. Аймгийн төв Мөрөн хот улсын нийслэлээс баруун хойш 671 км зайтай. Хөвсгөл аймаг Засаг захиргааны 149 нэгж: 23 сум, 1 тосгон, 125 багаас бүрддэг.

Хөвсгөл аймаг 100,629 км² дэвсгэр газар нутагтай Монгол Улсын 6 дахь том аймаг. Газрын гадаргын хувьд үндсэндээ уулархаг. Уул, ус, ой, хөвч, тайга бүхий байгалийн үзэсгэлэнтэй энэ нутаг төрөл бүрийн ашигт малтмал, амьтан ургамалаар баялаг. Цаг уурын ангиллаар хангайн бүсийн уулархаг мужид багтдаг, цаг агаарын хэлбэлзэл их, зуны хамгийн дулаан үе 7 дугаар сард +15-25 хэм, өвлийн хамгийн хүйтэн үе 1 дүгээр сард -24-49 хэм, зарим жилд -49-өөс -52 хэм хүрч хүйтэрдэг. Жилдээ нутгийн хойд хэсгээр дунджаар 300-400 мм, өмнөд хэсгээр 300мм хур тунадас буудаг.

Аймгийн эдийн засгийн гол салбар нь хөдөө аж ахуй, үүний дотор мал аж ахуй голлох байр эзэлдэг. 2020 оны дүнгээр 5500553 толгой малтай болсон ба малын тоогоор улсдаа тэргүүлдэг.⁵ Зарим сумдад газар тариалан эрхэлдэг. Жилд дунджаар 25000 орчим тонн үр тариа, 5000

⁵ Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийн байдал 2020/12 эмхэтгэл, 2021, Мөрөн

орчим тонн төмс, хүнсний ногоо хураан авч хүнсний хэрэгцээгээ дотооддоо хөдөө аж ахуйн салбараасаа хангадаг.

Монгол Улсын хамгийн олон хүн амтай Хөвсгөл аймгийн нийт хүн ам 135 095, үүнээс байнга оршин суудаг 134318, бөгөөд хүн амын 51,8% нь хот суурин газарт, 49,2% нь хөдөө амьдардаг. Хүн амын тоо 2010-2020 оны хооронд 11.75 мянган хүнээр буюу жилд дунджаар 1.9 хувиар өссөн байна. Нийт өрхийн тоо 37 914. Хөвсгөл аймгийн хүн ам нь насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байгаа ба 0-14 насны хүүхэд 31.6 хувь, 15-64 насны хүн ам 64.3 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 4.1 хувь эзэлж байна. Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа голч нас 26.8 болсон нь хүн амын тэн хагас нь 26.8-оос доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна. Нийт хүн амын 0.7 хувь нь буюу 933 хүн гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байна.⁶

Хүний халдварт өвчний нөхцөл байдал

2019 онд Хөвсгөл аймагт 2,280 хүн Вируст гепатит, Улаанууд, Гахай хавдар, Менингокк, Салхин цэцэг, Цусан суулга, Бруцеллёз, Гар хөл, амны өвчин халдварт өвчнөөр өвчилж, зоонозын халдварын хүний өвчлөлийн 37 тохиолдол лабораторын шинжилгээгээр батлагджээ.

2020 онд Аймгийн хэмжээнд 1388 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 2019 оны мөн үеэс 892 тохиолдол буюу 39.1 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 73.8 хувь, сүрьеэ 8.0 хувь, салхин цэцэг 5.0 хувийг тус тус эзэлж байна. Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний 1025 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 406 тохиолдол буюу 28.4 хувиар буурсан байна. Нийт тохиолдлоос тэмбүү 358 тохиолдол буюу 34.9 хувь, трихомониаз 110 тохиолдол буюу 10.7 хувь, гонококк халдвар 557 тохиолдол буюу 54.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 73.0 хувь, сүрьеэ 8.1 хувь, амьсгалын замын өвчин 10.2 хувь, арьс салтстаар халдварлах халдвар 0.8 хувь, цусан халдвар 0.7 хувь, гэдэсний халдварт өвчин 5.3 хувь, зоонозын болон мал амьтнаас хүнд халдварладаг өвчлөл 1.6 хувь, бусад халдварт өвчин 0.3 хувийг тус тус эзэлж байна⁷.

Зарим сумын төвийн хэрэглээний ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдал доройтсоноос үүдэн хүн амыг хамарсан гэдэсний суулгалтад халдварт өвчнүүд цусан суулга, сальмонеллёз, вируст гепатит тархах эрсдэл өндөртэйгээс гадна сүүлийн жилүүдэд уур амьсгалын

⁶ Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын Хөвсгөл аймгийн нэгдсэн дүн /Хураангуй/ Улаанбаатар, 2020

⁷ Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийн байдал 2020/12 эмхэтгэл, 2021, Мөрөн

өөрчлөлттэй холбоотой үерийн давтамж нэмэгдсэнээс орчны бохирдол нэмэгдэн халдварт өвчний гаралт нэмэгдэх магадлалтай байна.

Биологийн аюулын үнэлгээ

Биологийн гамшгийн эрсдэлийг үнэлэх арга зүйн үндсэн хэмжигдэхүүнүүд буюу гамшигтай тэмцэх чадавх, өртөнгө, эмзэг байдал, гэсэн гурван гол ойлголтод аюулыг нэмж багтаадаг. Өртөнгө, эмзэг байдал, чадавхын үзүүлэлтүүд нь аюулыг эрчимжүүлэх буюу хүч нэмэгдүүлэх эсвэл сулруулах нөлөөг аюулд үзүүлнэ. Өөрөөр хэлбэл биологийн гамшгийн эрсдэлийн хувьд аюул нь дараах байдлаар томъёологдоно:

- Шууд пропорциональ хамааралтай
- Шууд устгах буюу бууруулах боломжгүй,
- Хувьсан өөрчлөгдөх шинж чанаргүй тогтмол нөлөөтэй,
- Потенциаль занал үүсгэх, шийдвэрлэх нөлөө бүхий анхдагч хүчин зүйл,
- Объектив буюу хүний хүчин зүйл, хүсэл зоригоос хамааралгүй, дан ганц эх үүсвэр болдог

Аюул- хүн амын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулах, нийгэм-эдийн засгийн үйл ажиллагааг тасалдуулах эсвэл хүрээлэн буй орчинг доройтуулах ноцтой үйл явдал, үзэгдэл, эсвэл хүний үйл ажиллагаа юм.⁸ Ирээдүйд гамшиг учруулах нуугдмал нөхцөл байдал аюулд хамрагдаж болох бөгөөд янз бүрийн гаралтай: байгалийн /геологийн, ус, цаг уурын, биологийн/ эсвэл хүний үйл ажиллагаанаас үүссэн/хүрээлэн буй орчны доройтол, технологийн аюул/ байж болно⁹

Гамшгаас хамгаалах тухай хуульд “аюул” гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг. Харин био-аюулыг дээр дурдсан бүх төрлийн хоруу чанартай биологийн матер оршин байхыг хэлнэ гэж маш өргөнөөр ойлгож болно (Принстоны Их сургууль, 2018). Нөгөө талаас био аюул гэдэг нэр томъёо нь маш явцуу утгаараа лабораторийн нөхцөлд аюул занал үүсгэж буй боловч аюулгүй байдалд байгаа, энэ ангилалд багтахуйц бодис - юмс Merriam-Webster dictionary, 2018). Био –аюул гэдэг ухагдахуун бол гамшиг үүсгэх чадавх, боломжтой биологийн хүчин зүйлүүдэд өртөхийг ойлгодог. Магадлал ба

⁸ О.Үржин ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗҮЙН АСУУДАЛ 2020

⁹ Хёогогийн үйл ажиллагааны хүрээ /2005-2015/ баримт бичиг

үр дагаврыг тодорхойлсноор эдгээр үзүүлэлтүүдийн дагуу (биологийн) эрсдлийг тодорхойлохын ач холбогдлыг ойлгох болно.

Байгалийн жамаар үүсэх Пандемик \ тохиолдлу уд	Шинэ, сэргэж буй дахилтат халдварт өвчин	Судалгаа, шинжил- гээний явцад бий болсон алдаа, хүсээгүй үр дүнгүүд	Лабора- торын ослууд	Сэрэм жгүй байдла ас үүссэн нөхцөл байдал	Бодлогы н алдаа, буруу шийдвэр	Хайнга байдал, Стандарт үйл ажилла- гааны журам зөрчих	Гэмт хэрэг, хуурамч хортой эмийн зүйл	Хорлон сүйтгэх ажилла гаа	Халдлага дайралт	Биологи йн дайн, террори зм, тухайн улсын төрийн мэдлийн биологи йн зэвсэглэ л
Байгалийн жамаар	Санамсаргүйгээр									
	Санаатай үйлдэл									

Биологийн- эрсдэлийн спектр /Тейлор, 2006/

Маш олон төрлийн вирус, нян, мөөг, мөөгөнцөр, эгэл биетэн, шимэгчид, риккетсүүд нь аюултай өвчнүүдийн ангилалд багтах бичил биетэнүүд- биологийн гамшиг буюу цар тахал болж дэлгэрэх аюултай. Үүнээс зоонозын халдвар нь бусад өвчлөл, энгийн халдварын дотор бага хувийг эзэлдэг боловч сөрөг үр нөлөө, хохирлоороо нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хэмжээнд хүрдэг, хариу арга хэмжээ нь олон салбарын оролцоотой хэрэгждэг, нас баралт 30-100 хувьд хүрдэг өвөрмөц бүлэг өвчин юм¹⁰.


Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт сүүлийн 20 жилийн хугацаанд гоц халдварт өвчин болон хорио хязгаарлалт тогтоох зооноз өвчний бүртгэгдсэн тохиолдол жил бүр өсөх хандлагтай байна. Хөвсгөл аймгийн төв Мөрөн сумын нутаг дэвсгэр (Мөрөн сумын 14 баг) болон бусад сумын нутаг дэвсгэрт зоонозын халдварын голомтууд, өвчний үүсгэгчийн байдалд тус аймгийн Зоонозын өвчин судлалын төв, Мал эмнэлгийн газар хяналт тавьж, зоонозын халдварт өвчнөөс сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, зоонозын халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, өвчний хариу арга хэмжээг зохион байгуулдаг.

Тус аймагтай хиллэж байгаа ОХУ –ын БНТува Улс, БНБуриад Улс, тэдгээрийн хил орчмын бүсэд хилийн нэвтрэн орох цэгийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх, дамжсан халдвар гарах магадлал өндөртэй, залгаа бусад 3 аймагт харилцан, мал, амьтны галзуу, боом, тарваган тахал, хачигт

¹⁰ Зоонозын халдварт өвчний 2019 оны нөхцөл байдлын мэдээлэл, ЗӨСҮТ

халдвар зэрэг өвчнүүд дамжин халдварлах аюул байна. 2019 онд зоонозын халдварын хүний өвчлөлийн 37 тохиолдол, 2020 онд 19 тохиолдол лаборатороор батлагджээ.

Хөвсгөл аймагт тохиолдсон зоонозын халдварт өвчний сэжигтэй болон батлагдсан нийт тохиолдол 2008-2020 он



Хөвсгөл аймагт 2011-2020 онд тохиолдсон зоонозын халдварт өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдол, өвчнөөр, Зоонозын өвчин судлалын төв

	Өвчний нэр	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
Бруцеллёз		3	2	9	0	1	2	5	3	2	201	228
Хачигт риккетиз иоз	Батлагдсан	2	4	6	18	24	31	36	61	36	18	236
	Сэжигтэй	7	11	13	33	81	75	157	174	160	132	843
Хачигт энцефалит	Батлагдсан	0	0	1	0	4	0	5	0	0	2	12
	Эрсдэлд өртсөн	0	0	1	0	4	0	8	0	0	2	15
Хачигт боррелиоз	Батлагдсан	0	0	0	0	0	3		1	1	0	5
	Эрсдэлд өртсөн	0	0	0	0	0	3	1	2	3	0	9
Боом	Батлагдсан	0	0	0	1	1	0	0	0	0	0	2
	Эрсдэлд өртсөн	3	1	1	2	1	0	0	1	0	0	9
Галзуу	Батлагдсан	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Сэжигтэй	211	252	277	278	270	264	275	299	238	340	2704
Тарваган тахал	Батлагдсан	0	0	0	0	2	0	0	0	0	0	2
	Эрсдэлд өртсөн	0	0	0	1	2	2	2	2	2	3	14

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрийн зоонозын халдварын голомтууд

№	Өвчний нэр	Монгол орны байгалийн голомт	Хөвсгөл аймгийн голомт бүртгэгдсэн сумд
1	Тарваган тахал	17 аймгийн 137 сум	2020 онд Хөвсгөл аймгийн Зооноз өвчин судлалын төвөөс тарваган тахлын голомт бүхий сумдад тандалт хийхэд Баянзүрх, Цагаан-Уулд тарваган тахлын голомт идэвхтэй эрсдэлтэй байгааг тогтоосон байна. Ингэснээр тус аймгийн Төмөрбулаг, Шинэ-Идэр, Бүрэнтогтох, Цагаан-Уул, Арбулаг, Цэцэрлэг, Баянзүрх, Рашаант зэрэг 8 сум тарваган тахлын голомттой.
2	Боом	19 аймгийн 159 сум, нийслэлийн 2 дүүрэг	Ихэнх сумдад байгалийн голомт Ренчинлхүмбэ сум Мөрөн хотод хүний өвчлөлийн тохиолдол
3	Галзуу	21 аймгийн 285 сум, нийслэлийн 8 дүүрэг	Галзуугийн хүний өвчлөл харьцангуй цөөн бүртгэгдсэн ч Хөвсгөл аймагт сүүлийн 50 орчим жилд 2 хүн өвчилж нас барсан
4	Хачигт риккетсиоз	20 аймаг 87 сум, нийслэлийн 5 дүүрэг	Цагаан-үүр, Галт сум, Жаргалант, Алаг-Эрдэнэ, Эрдэнэбулган, Чандмань-Өндөр, Улаан-Уул, Баянзүрх, Бүрэнтогтох, Ханх, Төмөрбулаг, Цэцэрлэг Мөрөн сумдад голомт тэмдэглэгдсэн
5	Хачигт энцефалит	10 аймаг 22 сум, нийслэлийн 5 дүүрэг	Голомт бүртгэгдээгүй боловч, хөвсгөлчүүд голомт бүхий Сэлэнгэ, Булган аймгуудад байгалийн далалт баялаг олзворлох, голомттой газраас хүмүүс ирж ажиллах магадлалтай
6	Хачигт боррелиоз	7 аймгийн 13 сум, нийслэлийн 6 дүүрэг	Тодорхойгүй, нэмэгдэж байгаа
8	Бэтэг	Судалгаа эхэлж байна	2017 оноос тандалтыг эхлүүлснээс 1 суманд өвчлөл батлагдсан

Биологийн аюулын эх үүсвэр

Халдварт өвчний нөхцөл байдлыг өвчин тус бүрээр авч үзэж, Хөвсгөл аймгийн зооноз өвчний аюулын эх үүсвэрийг доорх байдлаар тодорхойлж байна.


А. Боом

Мал амьтны боом өвчин нь хөрсний халдвар үүсгэх гоц халдварт өвчин бөгөөд мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд, хөрсний халдвартай голомт үер уснаас болон барилгын ажлын явцад нээгдэх зөөгдөх, био терриоризм буюу боом өвчний хуурай өсгөвөр зэргээс хүн амын дунд халдвар тархах аюултай.¹¹

¹¹ Ш.Болдбаатар, НИЙСЛЭЛИЙН ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, 2020

Хөвсгөл аймаг нь боомын өвчин тэмдэглэгдсэн хөрсний голомт бүхий аймгуудтай хиллэж байгаагаас гадна тус аймгийн мал аж ахуйн голлох Цэцэрлэг, Галт сумд өндөр идэвхтэй, Бүрэнтогтох, Түнэл, Цагаан-Уул, Жаргалант, Рашаант, Ренчинлхүмбэ, Чандмань-Өндөр зэрэг сумдад дунд идэвжилтэй байхад бусад 14 сумдад боомын спороор хөрс бохирлогдсон байж болзошгүй, тэмдэглэгдээгүй голомт бүхий нутгуудтай зэрэгцээ оршиж байгаа нь үерийн үед задрах, барилгын газар шорооны ажлын үед нээгдэн өвчин гарах, боомын спор ургал хэлбэрт шилжсэнээс өвчин дэгдэх аюул байна. Хөвсгөл аймгийн төв Мөрөн сумын нутагт байгаа Далай ээж, Цагаан-Уул, Шинэмөрөн зэрэг хүнсний захад боомоор өвчилсөн малын мах, сүү зэрэг бүтээгдэхүүн орж ирж борлуулагдах, Мал нядалж, мах болон махан бүтээгдэхүүн боловсруулдаг Уудам хангай ХХК, Таван-Эрдэнэ ХХК, Агра нэгтгэл тренд ХХК, Баян шувууд ХХК, Лидэр хүнс ХХК, Хөвсгөл мах маркет ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтанууд халдварт өртөх, сум хоорондын зорчигч тээврийн автобус, хувийн тээврийн хэрэгслээр зорчин ирэгсэд баталгаагүй бүтээгдэхүүн авч орж ирэх нь боом өвчний халдвар тархах аюулын эх үүсвэр болж болзошгүй.

Монгол Улсын нутаг дэвсгэрт боом өвчний байгалийн голомт 2000-2019 онд, ЗӨСҮТ




Боом өвчний байгалын голомт идэвхтэй, Хөвсгөл аймаг малын боомын өвчлөлөөр тэргүүлдэг нь боомын хүний өвчлөл гарах эрсдэлтэй байгааг харуулж байгаа боловч хүний өвчлөл харьцангуй цөөн буюу,

тухайлбал 2014 онд 1, 2015 онд мөн 1 удаагийн хүний боомын тохиолдол бүртгэгдэж байжээ.

Б. Галзуугийн эрсдэлд өртсөн тохиолдол

Монголчуудын дунд галзуу өвчний талаарх мэдлэг, мэдээлэл эрт дээр үеэс байсан ч галзуу өвчнийг 1950 оны сүүлчээс албан ёсоор бүртгэж, оношилж, эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ирсэн байдаг. Галзуу өвчин нь тохиолдлын хувьд цөөн боловч өвчилсөн тухай бүр 100 хувь нас баралтаар төгсдөгт гол аюул нь оршдог. Монгол улсын хэмжээнд галзуугийн хүний өвчлөлийн тохиолдол 1972 оноос хойш 36 тохиолдол бүртгэгдэж, 100% нас баралтаар төгссөн.



Гадаадын улс орнуудад галзуугийн өндөр эрсдэлтэй тохиолдлуудын зөөвөрлөгч амьтад нь ихэнхдээ нохой муур, сарьсан багваахай эзэлдэг бол, монгол улсад нохой\60%\, чоно\22,9%\, таван хошуу мал\11,5%\ үнэг\3,2%\ зэрэг зэрлэг болон гэрийн тэжээмэл амьтад галзуу өвчний үндсэн дамжуулагч болдог байна. Б.Дэлгэрмаа,2019\

Мал, амьтны галзуу өвчин сүүлийн 20 жилийн хугацаанд Хөвсгөл аймгийн сумд, хил залгаа аймгуудын нутаг дэвсгэрт гэрийн тэжээвэр болон золбин нохой, чоно, үнэг зэрэг зэрлэгт амьтдад илэрсэн байна. Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт байгалийн голомт оршиж байгаагийн дээр бүх сумдад өвчлөх магадлал бүхий гэрийн тэжээвэр ба золбин нохой, муур зэрэг дамжуулагч амьтад байсаар байгаа, аймгийн Мал эмнэлгийн газраас мал тооллоготой хамтруулан гэрийн тэжээвэр амьтдын бүрэн бус тоог гаргадаг нь галзуу өвчний аюулыг буй болгож байна.

В. Хачигт халдвар


Монгол Улсад 2019 онд зоонозын өвчлөлийн 1100 тохиолдол бүртгэгдсэн. Үүний 80 гаруй хувь гэхээр 890 тохиолдол хачигт халдвараар бүртгэсэн гэсэн үг. Галзуу өвчний тохиолдол 100 гаруй, боом хоёр тохиолдол бүртгэгдээд байна. Хөвсгөл аймагт 2020 оны байдлаар хачигт риккетсиоз өвчний голомт харьцангуй өндөр, хачигт энцефалит, боррелиоз алаг цоог бүртгэгдэж байна.

2016 хийсэн судалгаагаар хачигт риккетсиозийн ДНХ Арбулаг, Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр сумдад тодорхойлогдож, 2020 онд Хөвсгөл аймгийн Зоонозын өвчин судлалын төв Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант, Бүрэнтогтох, Баянзүрх, Чандмань-Өндөр, Алаг-Эрдэнэ 7 сумын 68 секторт хачигт халдварын хайгуул шинжилгээг 2 удаа хийж нийт 1944 хачигт анхан шатны боловсруулалт хийж зүйлийн бүрдлийг тодорхойлон, 1120 хачгийг цуглуусан цэгт газар бүрээр хаягжуулан бүлэглэж ЗӨСҮТ-ийн вируслогийн болон шимэгч судлалын лабораторт хүргүүлсэн ба Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сумдаас цуглуулсан 187 хачгийг түүвэрлэн хачгаар дамжих халдварт өвчний үүсгэгчийн ДНХ, РНХ илрүүлэх молекул биологийн шинжилгээ хийхэд шинжилсэн хачгийн 82.35% нь хачигт риккетсиозын халдвартай болох нь батлагдсан.

Хачигт халдварын эрсдэлд өртсөн 163 тохиолдлыг шинжилгээнд хамруулж 37 нь халдвартай болох нь батлагдсан \I ийлдэс-163, II ийлдэс-77, III ийлдэс-1, нийт 307 ийлдэс\7 хачиг, шархны тав-1 шинжилгээнд илгээсэн\.

Г. Бэтэг өвчин

2017 оны 11-р сард Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Цэцэрлэг, Цагаан-Уул, Баянзүрх, Алаг-Эрдэнэ, Ренчинлхүмбэ, Мөрөн сумдад АШУҮИС-ийн багш н.Мөнхбаатар, биологич (багш) Д.Тэмүүлэн ЗӨСТ-ийн биологич Ү.Уяа-Эрдэнэ, лаборант Б.Мөнхтүвшин нар нар “Бэтэг өвчин ба шимэгчээр үүсдэг өвчнүүд”-ийн талаар 102 хүнийг хамруулсан судалгааны ажил хийжээ. Судалгаагаар Хөвсгөл аймагт бэтэг өвчин бага тохиолдож байна гэсэн дүгнэлт гарсан боловч малын (хонь, ямаа, үхэр) дунд өндөр байгаа, 2017 онд Мөрөн хотод бэтэг өвчний батлагдсан тохиолдол 1 бүртгэгдсэн байна.



Монгол Улсад 2017-2019 онд тохиолдсон бэтэг өвчний батлагдсан тохиолдол, Б.Дэлгэрмаа

№	Аймаг, аймаг	Сум	Тоо
1	Өмнөговь	Сэврэй	1
		Даланзадгад	1
2	Дорнод	Булган	1
3	Улаанбаатар	Баянзүрх	5
		Хан-Уул	2
		СХД	1
4	Төв	Зуунмод	1
5	Дархан-Уул	Дархан	1
6	Орхон	Баян-Өндөр	1
7	Хөвсгөл	Мөрөн	1
8	Завхан	Баянтэс	1
9	Увс	Ховд	1
	Бүгд		17


Д. Тарваган тахал

Монгол орны 17 аймгийн 137 сум тарваган тахлын байгалийн голомттой. ЗӨСҮТ-өөс 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хөрш зэргэлдээ улстай хамтарсан хил орчмын тандалтыг 6 удаа, салбар хоорондын болон салбар дундын байгууллагуудтай хамтарсан

тандалт 2 удаа, нийт 5378.8 км² талбайг хамруулан 9896 сорьц материал цуглуулан лабораторийн шинжилгээ хийж, 70 эерэг материал, 31 өсгөвөр илрүүлж, зоонозын халдварын байгалийн голомтын шинжилгээгээр Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Улаанхус, Бугат, Дорноговь аймгийн Замын-Үүд, Ховд аймгийн Цэцэг, Хөвсгөл аймгийн Баянзүрх, Цэцэрлэг, Цагаан-Уул сумдын нутагт тарваган тахлын эпизооти идэвхтэй байгааг тогтоожээ. Хөвсгөл аймаг байгалын идэвхтэй голомттой бөгөөд хөрш Завхан аймаг руу халдвар зөөвөрлөгдөн орж ирсэн тохиолдол 2020 онд бүртгэгдэж, байгалын голомттой Тува улсаас зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэл нэмэгдэж байгаа. Тарваган тахал халдварлах нөхцөл нь бусад тээврийн хэрэгслийн боомтоор тарваганы түүхий бүтээгдэхүүн зөөгдөн орж ирэх, хууль бус арилжаа явагдах, тарваганы эд эрхтэн, арьсыг зөөж авчрах, түүхийгээр эмийн болон хүнсний зорилгоор хэрэглэх нь тахал үүсэх, голомт гарах нөхцөлийг бүрдүүлнэ. Нөгөө талаар аялал зугаалгаар явж байгаа нь тахлаар халдварласан бүүрэгт хазуулах, тарвага, зурам, харх зэрэг мэрэгчидтэй харьцаж халдвар авах шалтгаан болох талтай [Ш.Болдбаатар, 2020].

Монгол Улсын аялал жуулчлалын тулгуур төв, төвийн бүсийн аймаг учраас тус аймгийн нутаг дээр жуулчны бааз, амралтын буудал ихээр байрлаж байгаа, орон нутгийн зорчигчид тарваганы мах, арьс зэрэг бүтээгдэхүүн хууль бусаар оруулж ирэх, хууль бус арилжаа наймаа хийх зэрэг нь тус аймагт тарваган тахал гарах аюулын эх үүсвэр болно.

Монгол Улсын тарваган тахал өвчний байгалийн голомт ба 2000-2019 онд тохиолдсон батлагдсан тохиолдол, ЗӨСҮТ



Е. Бусад халдвар

Газар хөдлөлт, үер зэрэг байгалийн гамшгийн дараа хоёрдогчоор хүн амын дундах халдварлал ихтэй гэдэсний суулгалт, халдварт шар, бруцеллёз зэрэг бусад өвчний гаралт, халдварлалт нэмэгдэх хэд хэдэн нөхцөл байна. Үерийн улмаас гэр хорооллын өндөрлөг хэсгээс бусад айлын хашаа хороо руу бохир урсан ариун цэврийн нөхцөлийг доройтуулах шалтгаан болж байна\Ш.Болдбаатар,2020\.

Хөвсгөл аймгийн төв болон зарим сумдын төвийн нутаг дэвсгэрийн гэр хорооллын нүхэн жорлонгийн бохирдолтой холилдсон үерийн лаг ирж тунах илүү эрсдэл үүсгэх газрын гадаргын тогтоцтой байна. Тухайлбал Хөвсгөл аймгийн Их-Уул суманд 2018 долдугаар сарын 19-ний өдөр орсон усархаг борооны улмаас үер бууж, 181 айл өрх усанд автаж, 169 хашаа нурж, тунасан ус, лаг шавар орон сууцны дунд, хүүхдийн тоглоомын талбай, зарим нийтийн эзэмшлийн талбайд үлдэн халдвар тархах нөхцөлийг бүрдүүлсний улмаас үерт өртсөн айл өрх болон нийтийн эзэмшлийн 32.8 га талбайд ариутгал халдваргүйтэл хийх, лаг шаврыг цэвэрлэх, үерийн далан сэргээн засварлах ажлуудыг зохион байгуулж байжээ. Нөгөө талаар аймгийн төвд ариун цэврийн нөхцөл хангаагүй ил задгай мал аж ахуйн бүтээгдэхүүн, хүнсний ногооны зөвшөөрөлгүй худалдаа арилжаа тодорхой хэмжээгээр явагдаж байгаа нь хүн амын дундах гэдэсний халдварт суулгалт өвчин, халдварт гепатит, бруцеллёз, сүрьеэ зэрэг нийгмийн халдварт өвчин гарах, тархах, нөхцөлийг бүрдүүлж байна.

Аюул үүсэх шалтгаан нөхцөл

Галзуу өвчин- Хөвсгөл аймгийн нийт 37914 өрхийн, 23 сумын 26227 өрх, аймгийн төв Мөрөн хотын 11687 өрх айлын тэжээвэр нохой, муурын бүртгэл судалгааг мал 2020 оны жилийн эцсийн мал тооллоготой хамтруулан аймгийн Мал эмнэлгийн газараас эхлүүлжээ. “Хот суурин газрын золбин нохой тоолох” арга зүйг баримтлан хамгийн их хүн ам төвлөрсөн, золбин нохойн тоошил харьцангуй их Мөрөн сумыг сонгон золбин нохойн тооллого болон нохойгоор дамжих халдварт өвчний эрсдлийг үнэлэх тандал судалгааг 2019 оны 4-р сарын 2-аас 5 хүртэл Мөрөн сумын 14 багийн нийт 524 гудамжны 49%-ийг хамруулан сонгосон 257 талбайд золбин нохойн тооллогыг хийж нийт 261 золбин нохой тоолсон ба тооллогоор сумын 1км² талбайд дунджаар 39.3 золбин нохой тоологдсон \В.Баярдалай нар, 2019\.

Золбин нохойн нягтшил захын багуудад өндөр, хүнс, түүхий эдийн зах байршдаг багуудад эм гөлөг, залуу

бодгаль илүү тоологдож, тооллогод хамрагдсан золбин нохойн 65.5% нь бие гүйцсэн, 91.2% нь эр, хүзүүвч бүхий эзэнтэй нохой эзэлж байв. 2018 оны тооллогын дүнтэй харьцуулахад нягтшил 5.6-аар өндөр байв.¹²

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын золбин нохойн тооллогын ерөнхий дүн, 2019 он, Зоонозын өвчин судлалын төв

Баг	Маршрутын тоо	Тоолсон нохойн тоо	Тооллого хийсэн 1км2 дахь нягтшил	Багийн нийт талбайд байж болох нохойн тоо
1-р баг	19	13	34.3	1615
2-р баг	17	14	39.7	795
3-р баг	16	7	15.9	301
4-р баг	14	8	23.2	460
5-р баг	19	27	47.8	1067
6-р баг	21	16	23.4	444
7-р баг	16	23	57.0	2626
8-р баг	10	14	46.7	1232
9-р баг	12	16	64.0	1155
10-р баг	24	23	34.8	2181
11-р баг	24	28	44.0	878
12-р баг	12	19	56.7	1166
13-р баг	31	23	32.2	2583
14-р баг	22	30	45.1	1587
	257	261	39.3	1292

Мөрөн сумын 14 багийн нутаг дэвсгэрт 1292 золбин нохой байгаагийн дээр тус аймгийн 23 сумаас 19 нь галзуу өвчний байгалийн голомттой бөгөөд сүүлийн жилүүдэд өвчний идэвхжил өндөр байгаа, түүнчлэн урин дулааны цагт өвчний вирүс илүү сэргэж, хаврын улиралд зэрлэг амьтдын зан араншин өөрчлөгддөг учраас ихэвчлэн галзуурсан үнэг, хярс, дорго, мануул зэрэг зэрлэг амьтад айлын малруу дайрах, айлын нохой ноцох зэргээр илэрч байна. Ийнхүү галзуу өвчний байгалийн голомттой зэрэгцэн оршиж байгаа нь гэрийн нохой халдвар авах нөхцөлийг бүрдүүлж байна. Гэр хороололд байгаа нохойг тогтмол уянд байлгадаггүй, шөнийн цагаар сул тавьдаг, мөн золбин нохой цөөнгүй тоотой байгаа нь хүмүүс нохойд уруулах, хазуулах халдвар авах нөхцөлийг бүрдүүлж байна. Мөрөн сумын хэмжээнд эзэнгүй нохой, өөрийн гэрийн тэжээвэр нохойдоо уруулах тохиолдол тогтмол их байдаг.

Боом өвчин- тархах аюул үүсэх дараах хоёр томоохон нөхцөл байна. Нэгд тус аймгийн нийт өрхийн 44,6% буюу 16910 малчин өрх мал аж ахуйн өдөр тутмын үйл ажиллагааны явцад шууд байдлаар халдварт өртөх, халдвар дамжуулах нөхцөл бодитоор байна. Учир нь

¹² Хөвсгөл аймгийн ЗӨСТ-ийн 2019 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан

Хөвсгөл аймаг 2020 оны жилийн эцсийн Мал тооллогын дүнгээр 5500553 толгой мал тоолуулж, улсад тэргүүлж, нийт малаар улсад 1, Үхрээр 2, Хониор 2, Ямаагаар 3-р байранд тус тус орсон ба Хөвсгөл аймагт 271528 толгой адуу, 501080 толгой үхэр, 2284 толгой тэмээ, 2622814 толгой хонь, 2102847 толгой ямаа, 6 дахь хошуу мал-цаан сүрэг 3127 тоологдож өмнөх оноос 18.6 хувь буюу 491 толгойгоор өсжээ.

Хоёрт сум хоорондын зорчигч тээвэр, орон нутгийн замын дагуу боом өвчнөөр халдварлагдсан малын мах, сүү, арьс шир зөөвөрлөгдөх орж ирэх түүнийг Мөрөн хотын тээврийн товчоо, малын түүхий эд, хүнсний захын завсарын ченж наймаачид, мах боловсруулах аж ахуйн нэгж байгуулгын гэрээт бэлтгэн нийлүүлэгчид худалдан борлуулахад өвчин гарах, улмаар ил задгай хүнсний худалдааны цэгийн хүнсний бүтээгдэхүүний бохирдол үүссэнээс үүдэн суурийн газрын хүн амд тархах нөхцөл бүрдэхээр байна. Нөгөө талаар сум, багийн төвд мал бүхий хүмүүсийн байршил байсан боом өвчний тэмдэглэгддэггүй голомт бүхий газруудын голомт үерийн болон барилгажуулалтын ажлын улмаас голомт задран идэвхжих өвчин шинээр үүсэх, боомын үүсгэгчтэй лаг хуримтлагдан боом өвчин гарах шалтгаан нөхцөл болохоор байна.

Тарваган тахал- халдварлах нөхцөл нь өвчтэй тарвага агнах, арьс өвчих, мах эвдэх зэрэг үйл ажиллагааны тахлаар өвчилсөн тарваганы мах, махан бүтээгдэхүүнийг дутуу боловсруулан хэрэглэх явцад, мэрэгч амьтдын бөөс, бүүрэг, цус сорогч үе хөлтөн хазуулах зэрэг тохиолдлуудад халдварлана.¹³ түүнчлэн зорчигч тээврийн хэрэгслээр тарваганы түүхий эд, бүтээгдэхүүн зөөгдөн орж ирэх, хууль бус арилжаа явагдах, тарваганы эд эрхтэн, арьсыг хөдөө, орон нутгаас зөөж авчрах, түүхийгээр эмийн болон хүнсний зорилгоор хэрэглэх нь тахал үүсэх, голомт гарах нөхцөлийг бүрдүүлнэ. Нөгөө талаар ид тахлын идэвхижилттэй зун, намрын улиралд суурин газар амьдардаг хүмүүсийн амралт эхэлж, аялал зугаалгаар голомтод бүс нутагт зорчиж байгаа нь тахлаар халдварлах шалтгаан болох талтай.

Тус аймгийн Төмөрбулаг, Шинэ-Идэр, Бүрэнтогтох, Цагаан-Уул, Арбулаг, Цэцэрлэг, Баянзүрх, Рашаант сумдад тарваган тахлын голомт идэвхтэй эрсдэлтэй байгааг тогтоосон учраас ард иргэдийг эдгээр 8 сумын голомт бүхий газруудаас тарвага агнахгүй, тарваганы түүхий эд

¹³ Эрүүл мэндийн сайдын 2002 оны 166 тоот тушаалын нэгдүгээр хавсралт тарваган тахал өвчинтэй тэмцэх арга хэмжээний заавар

эрхтэн, тулам худалдан авч хэрэглэхгүй байхыг анхааруулах нь чухал байна.

Мал, амьтны гоц халдварт болон зооноз өвчний аюул үүсэх шалтгааны нэгтгэл

Зоо- нозууд	Галзуу	Боом	Бэтэгтэх	Тарваган тахал	Хачигт халдварууд	Холер түүнтэй төст өвчнүүд
Үүсэх шалтгаан нөхцөл	Нохой байгалийн голомттой харьцах, нохойд хазуулах шүлсдэх	Боом өвчтэй малтай харьцах, малын гаралтай бүтээгдэхүү н,арьс ширтэй харьцах	Бохирдсо н хүнс, бохир гараар дамжин халдварла на	Өвчтэй тар- ваганы мах, түүхий эд хэрэглэх	голомттой газарт оршин суух ойгоор аялах, мал хариулах, мод бэлтгэх, ургамал түүх үед хачиг хазаснаас	Үерийн улмаас бохирдол хуралдах, ус ариун цэврийн нөхцөл муудах
Хамрах хүрээ	Байгалийн голомттой харь- цан голомтлон гарах	Хүнсний зах, суурин газар, голомтлон гарна, уушгины хэлбэр түргэн олон газарт тархана	Дэлхийн хойд өргөргийн 38° хойш оршдог орнууд, Монгол оронд элбэг тархсан	Тахалтай газраас зөөгдөх, уушгины хэлбэр түргэн тархах	Сэлэнгэ, Булган аймгаас дийлэнх тохиолдол	Бохирдол бүхий нутагт голомтлон гарах
Давтамж	4-5 хэмнэлт давтамжтай	10-12 жилийн давтамжтай	Улиралчл ал, үечлэл тодорхойл огдоогүй	Голомтын идэвхжлээ с шалтгаалд аг	Хаврын улиралд тохиолдол н эмэгддэж, 50 гаруй% нь 6- 8 дугаар сард бүртгэг ддэг.	Давтамж нь нэмэгдэж байна.м
Эрт илрэх дохио, шинж тэмдэг	Дамжуула гч амьтдын тоо олшрох, ороо хөөцөлдөө н нэмэгдэх	Голомтууд идэвхжих, цаг уурын гэнэтийн үзэгдэл тохиолдох	Хамааралг үй	Голомтуу д идэвхжих өвчний тохиолдол бусад бүс аймаг сумдад бүртгэгдэ х	Голомтууд идэвхжих өвчний тохиолдол бусад бүс аймаг сумдад бүртгэгдэх	Үер гэх мэт гэнэтийн гамшигт үзэгдэл үр дагавар
Үргэлжлэ х хугацаа	Өвчний нууц үе нь 20-60 хоног	Өвчний далд үе 1-7 хоног	Өвчний далд үе 12 сараас 10 жил хүртэл	Уушгины хэлбэр 1 - 3 өдөр, булчирхай	Өвчний далд үе 7-14 хоног	Өвчний төрлөөс хамааран 5- 12 өдөр

				н хэлбэр 2-6 өдөр		
Хор хөнөөл	Хүний эрүүл мэнд, амь нас Хязгаарла лтын зардал	Хүний амь нас, эрүүл мэнд Хөл хорио, хүнсний аюулгүй байдал муудах,	Эмнэлзүй н хүндрэл тохиолдох бохирдсон орчиноор дамжин цааш халдварла х	Хүний амь нас, эрүүл мэндэд нөлөөлөх, хөл хорио, гадаад, дотоод зах зээлийн хориг	төв мэдрэлийн тогтолцооны гэмтлээр илэрдэг, хүндрэл, үлдэц ихтэй	Хүнсний аюулгүй байдал, Эрүүл мэнд, өрх гэрийн эдийн засгийн бэрхшээл
Аюулын түвшин	Аюулын түвшин дунд зэрэг	Аюулын түвшин дунд зэрэг	Аюулын түвшин дунд зэрэг	Уушгины хэлбэр эрсдэл өндөртэй, ОУЭМД дагуу ДЭМБ мэдээлнэ	Аюулын түвшин дунд зэрэг	Холер өвчний аюулын төвшин өндөр

Аюулын хамрах хүрээ

Галзуу, боом зэрэг зооноз өвчний аюулын хамрах хүрээний хувьд голомтлон тухайн сум, аймаг, баг хороо, нутаг дэвсгэрт гарах ч боом өвчний уушгины хэлбэр, болзошгүй лабораторын осол тохиолдвол түргэн хугацаанд олон хүнд халдварлаж болзошгүй \Ш.Болдбаатар,2020\.

Тарваган тахал нь хамрах хүрээний хувьд хот суурин газарт маш түргэн хугацаанд олон хүнд дамжин өргөн цар хүрээтэй тархах боломжтой. Энэ нь Мөрөн хотын нутаг дэвсгэрийн хязгаарлагдмал байдал, хүн амын нягтрал, суурьшил зэрэгтэй холбоотой. Тарваган тахалын хавьталын цар хүрээ Хөвсгөл аймагт түргэн хугацаанд дотоодын аялал жуулчлалын хөдөлгөөнтэй холбоотойгоор тэлэх магадлал өндөр. Гамшигт үзэгдлээс үүсэх суулгалтад-халдварт өвчнүүд аажим тархалттай ч олон хүн амын хамрах магадлал ихтэй.

Аюулын үргэлжлэх хугацаа

Тарваган тахлын үед 6 хоногийн хорио цээр тогтоон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын саналыг үндэслэн татан буулгах, сунгахыг Улсын онцгой комисс шийдвэрлэнэ. Галзуу өвчин гарсан үед 7 хоногийн хугацаатай хязгаарлалтын арга хэмжээ авагддаг бол мал,амьтны гоц халдварт боом өвчний үед 14 хоногийн, шүлхий өвчний үед 21 хоног хорио цээр тогтооно. Цусан суулга, зэрэг гэдэсний халдварт суулгалтад өвчний далд үе 7-14 хоног ба эмчилгээний 14- 21 хоног үргэлжилдэг.

Харин бруцеллёз, зэрэг зооноз өвчний нууц үе болон үргэлжлэх хугацаа харьцангуй урт байдаг.

Аюул тохиолдох давтамж


Монгол улсад сүүлийн жилүүдэд илэрч буй уур амьсгалын өөрчлөлтөй холбоотойгоор байгалийн голомтууд сэргэн идэвхжиж хүн, малын боомын боом өвчний гаралт, тархалт 4-5 жилийн давтамжтай улам нэмэгдсээр байна. Жилд зоонозын хүний өвчлөлийн 300-500, 26000 гаруй мал, амьтаны өвчлөлийн тохиолдол бүртгэгдэж байна.

Сүүлийн 20 гаруй жилд 18 аймгийн 94 суманд 1294 малын боом, 16 аймгийн 56 суманд 143 хүний боомын тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Хөвсгөл аймгийн малын боом өвчний 1964-2015 онуудад тэмдэглэсэн дүн мэдээг нэгтгэн статистик боловсруулалт хийж үзэхэд нийт 51 жилийн 39 жилд нь боом өвчин бүртгэгдсэн бөгөөд 1983 оноос 2015 он хүртэл тасралтгүй гарсан байна. 1964 оноос хойш нийт 425 голомт бүртгэгдэж, 1580 мал өвчилснөөс үхэр 1182 буюу 75%, хонь 162 10%, адуу 157 буюу 9,9%, ямаа 62 буюу 4%, малын төрөл тодорхойгүй 17 буюу 1,1% эзэлжээ. Үүнээс 2000, 2015 онуудад хамгийн их дэгдэлт бүртгэгдсэн бөгөөд 2000 онд 23 голомтод 175 үхэр, 19 хонь үхсэн байсан бол 2015 онд 31 голомтод 151 адуу, 15 үхэр, 7 ямаа үхсэн байна¹⁴. Гэтэл хүний боом өвчлөл сүүлийн 10 жилийн хугацаанд Хөвсгөл аймагт 2 удаа үүсгэвэрлэн гарсан нь зоонозын өвчний эрсдэлийг бууруулах чадавхи сайн байгааг харуулж байна.

Галзуу өвчин 10-12 жилийн давтамжтай байгалийн голомтын идэвхжилтэй холбоотой байдаг бөгөөд 2013 оноос эхэлж 2019 он хүртэл үргэлжилсэн сүүлийн идэвхжлийн тохиолдол буурч байна. 2023-2024 онд дахин шинэ идэвхжил сэргэх магадлал өндөртэй.

¹⁴ Н. Норов*, Б. Лхам, Ц. Батболд, О. Хурцбаатар, З. Түвшинзаяа, Н. Энхцэцэг, Ж. Энхтуяа Хөвсгөл аймгийн боомын голомтын мэдээлэл 2017

Монгол Улсад тохиолдож буй мал, амьтны галзуугийн өвчлөлийн чиг хандлага, ЗӨСҮТ



Монгол Улс нь тарваган тахал өвчний байгалийн голомт бүхий бүс нутаг манай улсын 17 аймгийн 137 сумын нутагт янз бүрийн идэвхжилтэй байгалийн голомт байдаг нь жил бүр өвчин сэргэн идэвхжиж байх нөхцөлийг бүрдүүлдэг. Сүүлийн 20 жилд тарваган тахлын хүний өвчний 71 тохиолдол бүртгэгдэж, 24 (CFR 33.8%) нь нас барсан. 2015 онд 2019 онд 7 удаагийн сэжигтэй дуудлага бүртгэгдсэнээс Баян-Өлгий аймагт 2 хүн өвдөж, үжил хэлбэрээр хүндэрч нас барсан. 2020 онд Монгол Улсад тарваган тахлын сэжигтэй 16 тохиолдол бүртгэгдсэнээс таван тохиолдол батлагдлаа. Үүнд 8-р сарын 27-нд 38 настай эрэгтэй Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум буюу голомттой газраас тарвага авч, өвчиж, чанаж идээд хил залгаа Завхан аймгийн Тосонцэнгэл суманд ирээд өвчилж, биеийн байдал маш хүндэрсэний улмаас нас барсан ба уг сэжигтэй тохиолдол молекул биологийн шинжилгээгээр тарваган тахал өвчний тохиолдол гэдэг нь батлагдсан. Мэргэжлийн эмч нарын баг голомтод ажиллан, 1-р хавьтлын 25 хүнийг тусгаарлаж эмнэлэгийн тогтмол хяналтанд авснаар, Тосонцэнгэл сумын хэмжээнд хорио цээрийн дэглэмийг 2020 оны 09 сарын 05-ны 00 цагаас 09 сарын 11 ний 23 цаг 59 минут хүртэл тогтоожээ.

1983 оноос хойш Хөвсгөл аймагт тарваган тахлын байгалийн голомт 2 удаа идэвхжиж 8 хүн өвчилж 2007 онд 1, 2015 онд 1 хүн нас барсан. Мөн Хөвсгөл аймгийн ЗӨСТ тарваган тахлын байгалийн голомтын судалгааг холбогдох заавруудыг баримтлан 2019 онд гүнзгийрэл 1, хайгуул 2 хэлбэрээр 3 удаа хийсэн. 2020 онд Завхан аймагт бүртгэгдсэн тарваган тахлын хүний өвчлөлийн дээр дурьдсан тохиолдлын халдварын эх уурхайг илрүүлэх тандал судалгааг хийж 149 шинжилгээний сорьц материалыг цуглуулан ийлдэс, нян, амь судлалын шинжилгээнд

хамруулан тарваганы үхдэл болон түүний бүүрэг, бөөснөөс нян судлалаар тус тус тарваган тахлын үүсгэгч /Yersinia pestis/ илрүүлэн эпизоотологийн холбогдолыг тогтоосон байна¹⁵.

Аюулын түвшин

Зоонозын халдвар нь бусад өвчлөл, энгийн халдварын дотор бага хувийг эзэлдэг боловч сөрөг үр нөлөө, хохирлоороо нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хэмжээнд хүрдэг, хариу арга хэмжээ нь олон салбарын оролцоотой хэрэгждэг өвөрмөц бүлэг өвчин бөгөөд зоонозоос өөр нас баралт 30-100 хувьд хүрдэг өвчин байхгүй.¹⁶

Хөвсгөл аймгийн Мөрөн хотод тохиолдож болох зоонозын халдварт өвчний аюулын түвшинг Хөвсгөл аймгийн гамшгаас хамгаалах орон тооны бус албад, мэргэжлийн ангийн ажилтан алба хаагчид, иргэдийн оролцоотой эрэмбэлэн, тусгай шалгуур ашиглан тодорхойлсон дүнг доорх хүснэгтэд харуулав.

Хөвсгөл аймгийн халдварт болон зооноз өвчний аюулын түвшин

Аюулын төрөл	Галзуу	Боом	Хачигт халдвар	Тарваган тахал	Халдварт суулгалт
Нийт авсан оноо	2	6	0	8	4
Аюулын түвшин	IV	II	V	I	III

Тайлбар: I, II-өндөр, III-дунд зэргийн, IV, V-бага зэрэг

Мал, амьтны гоц халдварт, зоонозын өвчний аюулын үнэлгээний тоон утгыг өгөхдөө аюулын 6 шалгуурыг баримтлана \Б.Дэлгэрмаа, 2019\.

Үүнд:

1. Нян, вирус өсгөвөрлөгдөх,
2. Эерэг материал илрэх;
3. Хил дамнан халдварлах эсэх;
4. Урьд өмнө бүртгэгдэж байсан эсэх;
5. Халдварлалтын түвшин;
6. Олон нийтэд түгшүүр төрүүлэх эсэх

Хүснэгтээс үзэхэд Хөвсгөл аймгийн хувьд тарваган тахлын халдвар дамжин орж ирвэл аюулын маш өндөр түвшинтэй байгаа бол боом өвчин өндөр, гэдэсний халдварт суулгалтад өвчин (холер) тархалтын аюулын

¹⁵ Хөвсгөл аймгийн ЗӨСТ-ийн 2020 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан

¹⁶ Зоонозын халдварт өвчний 2019 оны нөхцөл байдлын мэдээлэл, ЗӨСҮТ

түвшин дунд, галзуу өвчний аюулын түвшинг бага гэсэн хачигт халдвар ач холбогдол бага гэж үзсэн байна.

Аюулын зураглал

Хөвсгөл аймаг гоц халдварт зооноз өвчний тархалтын 2 зам байна.

Үүнд:

- 1-рт хил даван өөр улс, аймгаас зөөвөрлөгдөх халдвар. Хил залгаа орших ОХУ -ын Бүгд найрамдах улс, бусад мужуудаас Ханх-Мондын хилийн боомт, эсвэл зах залгаа аймгууд, түүнчлэн бусад аймаг, нийслэлээс ирэх гол цэг Тариалан, Их-Уул, Төмөрбулаг, Галт, Жаргалант, Шинэ-Идэр, Цэцэрлэг сумдын нутаг дэвсгэрийн урд, зүүн ба баруун урд талын хэсгүүд тэнд байрлах багийн төв, айл өрх, замын үйлчилгээний цэг, дэлгүүр - худалдаа, агаарын болон авто тээвэр, ердийн хөсгөөр нэвтрэх, малыг хөлөөр тууварлах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн нэвтрэх хэсгүүд гэдэг нь аюулын зургаас харагдаж байна.
- 2-рт Хөвсгөл аймгийн нутагт байгаа зооноз байгалийн өвчний голомтууд идэвхжиж дотооддоо халдварлах. Түүнчлэн Мөрөн сумын 1, 13,14 дугаар хорооны нутагт үерийн улмаас боом, гэдэсний халдварт суулгалтад өвчний бохирдол үүсэх түүнээс үүдэн өвчин гарах өндөр магадлалтай байна.

2010 оноос “Боом өвчинтэй тэмцэх сэргийлэх стратеги боловсруулах”-ын тулд хүн, малын боомын өвчлөлийн мэдээлэлийн сан бүрдүүлэх, боомын голомтын зураглал гаргах, боомын дэгдэлт болон голомтын идэвхжлийг байгалийн хүчин зүйл (цаг уурын мэдээ, уур амьсгалын өөрчлөлт, хөрсний бүтэц, байгалийн эсрэгбие) болон хүний хүчин зүйл (малын шилжилт хөдөлгөөн, уул уурхайн олборлолт, вакцинжуулалтын чанар, малчдын мэдлэг, зан үйл)-тэй харьцуулан тодорхойлох зэрэг ажлуудыг хийжээ. \Н.Норов, 2017\ Тэмцэх сэргийлэх ажлын хамгийн гол үндэс суурь нь боомын голомтыг газар зүйн байршлаар нарийвчлан гаргаж идэвхжлийг тогтоох явдал юм¹⁷. Мал эмнэлгийн мэдээгээр 1996-2016 онд Монгол Улсын 19 аймгийн 164 сумын нутагт малын боом өвчин бүртгэгдсэн байгаагаас Хөвсгөл аймагт дийлэнх нь байна.¹⁸ Хөвсгөл аймаг нь газарзүйн байршлын хувьд боом өвчний байнгын идэвхтэй голомт

¹⁷ Н. Норов*, Б. Лхам, Ц. Батболд, О. Хурцбаатар, З. Түвшинзаяа, Н. Энхцэцэг, Ж. Энхтуяа Хөвсгөл аймгийн боомын голомтын мэдээлэл 2017

¹⁸ Дэлхийн банкны “шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх төсөл”ийн Боом өвчний голомтын судалгаа төслийн тайлан Улаанбаатар хот 2014


бүхий өндөр эрсдэлтэй бүсэд оршдог¹⁹. Малын боом өвчний 425 голомтын 98 буюу 23% нь GPS –ийн цэгийн бүртгэлтэй байгааг ашиглан анхан шатны зураглал гаргажээ. Зураг 1-т үзүүлэв.

Хөвсгөл аймгийн малын боом өвчний голомтын анхан шатны зураглал



Тарваганы 315 бүлд ажиглалт
312 га-д тарваганы тооллого
108 га-д дагуурын огдойн
65 га-д үлийн цагаан оготны
24 га-д урт сүүлт зурамны тооллого /маршрутын 4зүйл мэргэчийн
177 амьтан олзворлож
2 зүйл мэргэчийн 5 ноохой ухаж,
4 зүйл мэргэчийн 2635 нүх үзэж нийт **21549** гадны шимэгч цуглуулан агуулагч, дамжуулагчийн судалгааг гаргасан. Тарваган тахлын байгалийн голомтоос БГХШ-ээр дээжилсэн **1907** нэгж сорьцыг нян, ийлдэс, амь судлалын шинжилгээнд хамруулахад сөрөөрөг материал илрээгүй

¹⁹ Батсуурь.Н “Монгол дахь бактерит зарим зооноз өвчний тархалт, эрсдэлийн түвшингийн судалгаа” Мал эмнэлгийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар 2003



ДҮГНЭЛТ

Хөвсгөл аймаг нь Монгол Улсын төвийн буюу хангайн бүсийн нийгэм-эдийн засгийн өвөрмөц онцлогтой, статистикийн олон үзүүлэлтээр улсдаа тэргүүлдэг нь биологийн зарим төрлийн аюул тохиолдох эрсдэлийг тэр хэмжээгээр нэмэгдүүлдэг. Хүн амын талаас илүү хувь нь аймгийн төв, болон суурин газруудад суурьшмал амьдардаг, хувийн аж ахуйтай, мал малладаг айл өрх (үхэр, хонь) боомын өвчлөл, голомт бүртгэгдсэн Мөрөн суманд байдаг. Хөвсгөлчүүд хүнсний хэрэгцээгээ дотооддоо хөдөө аж ахуйн салбараасаа хангадаг ба аймгийн МХГ аас тогтмол бус байдлаар хүнс бэлтгэл, үйлдвэрлэл, түгээлт, үйлчилгээ зэрэг үе шатанд шинжилгээ хийж, хянадаг бол Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт зоонозын халдварын голомтууд, өвчний үүсгэгчийн байдал Зоонозын өвчин судлалын төв хяналт тавьж, халдваргүйжүүлэлтийг хариуцан ажилладаг.

Малын тоо толгой, гэрийн тэжээвэр амьтан ихтэй нь мал, амьтны гоц халдварт болон зоонозын хорио, хязгаарлалт үүсгэх өвчний аюул харьцангуй их байна. Мөн эдгээр өвчний байгалийн болон орчны голомт агуулсан бусад аймаг, аймаг сумуудтай шууд харьцаж байгаа нь мал, амьтны боом, галзуу, тарваган тахал болон бусад өвчнүүд гарах тархах нөхцөлийг бүрдүүлж байна.

Хөвсгөл аймгийн зарим сумдын төв, суурьшилын бүст харьяалагдах нутаг дэвсгэр нь нам дор, хэвгийд байршилтай байгаа нь өндөрлөг байршилтай бусад сум багийн мал, амьтны халдварт өвчний голомт бүхий нутгуудаас боом, гэдэсний халдварт өвчний халдварын эх үүсвэр зөөгдөн орчныг бохирдуулах, малын халдварт өвчний аюулд эмзэг

байдлыг буй болгож байна. Үерийн усаар хөрс идэгдэх, газар шороо барилгын ажлын үед боомын голомт задрах эрсдэл өндөртөйд тооцогдож байна.

Гэр хорооллын ариун цэврийн байгууламж, ус, эрүүл мэндийн дэглэм муу, үерээс үүссэн хог, хаягдлыг цаг тухайд цэвэрлэж, халдваргүйтгэл хийгдэхгүй байгаа нь боом болон гэдэсний халдварт өвчний өртөлтийг нэмэгдүүлж байна.

Хөвсгөл аймгийн нутагт байрлах захуудын хүнсний болон түүхий эд бэлтгэлийн систем, тээврийн хэрэгсэл нэвтрэх замаар тус аймгийн төв Мөрөн хотод тарваган тахал зөөгдөх эрсдэл бүхий бүтээгдэхүүн нэвтрэх аюулын зэрэг өндөр, иргэд тарваганы мах идэх дуртай, цуу ярианд автаж эмчилгээний зорилгоор хэрэглэх, тарваган тахал үүсгэх эх үүсвэр нь зөөгдөн халдвар тархвал зэргэлдээх аймаг, сумдыг хамран тархах аюулын түвшин өндөр байна.

Хөвсгөл аймгийн бүх хороодын нутаг дэвсгэрт 2020 оны жилийн эцсээр айл өрхийн нохой, муурыг бүртгэлжүүлэх ажлыг дахин эхлүүлсэн боловч гэр хороолол бүхий зарим сум багийн хэмжээнд золбин ноход их байгаа, гэрийн тэжээвэр нохойн уяа, хяналт сайн биш, нийт нохойд вакцинжуулалт хийгдэхгүй галзуу нохойд нэвт хазуулж уруулсан шарх, шарханд хүрсэн галзуу амьтны шүлс, хүний хүзүү толгойд үүссэн шархаар дамжин галзуу өвчний үүсгэгч нэвтрэх эрсдэл байгаа нь мал амьтны галзуу өвчин хүн амын дунд гарах аюулыг нөхцөлдүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

- Хөвсгөл аймагт мал, амьтны гоц халдварт болон зооноз өвний халдварын аюулыг бууруулахын тулд улсын болон орон нутгийн замаар мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн нэвтрүүлэх хяналтыг эрс сайжруулах,
- Мөрөн сум, Хатгал тосгон зэрэг суурин газруудад үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний бүтээгдэхүүний (мах, сүү, хүнсний ногоо) гар дээрээс хийгдэж байгаа худалдааг таслан зогсоосон байдлаа цаашид үргэлжлүүлэх, хууль бус арилжаа явуулахгүй байхад төрийн болон мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт тавьж ажиллах,
- Хөвсгөл аймгийн нутагт байгаа бүртгэлтэй бүх нохойг галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад бүрэн хамруулж золбин ноходыг устган, нохойн хөдөлгөөн, арчилгаанд анхаарал тавьж ажиллах,

- Мал, амьтны гоц халдварт болон зооноз боом, тарваган тахал, галзуу өвчний нэрвэгдэлтийн дараах урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээний зохистой дадлыг зохих эрүүл мэндийн байгууллагуудад стандарт болгон нэвтрүүлэх.

Ашигласан материал

1. Батсуурь.Н “Монгол дахь бактерит зарим зооноз өвчний тархалт, эрсдэлийн түвшингийн судалгаа” Мал эмнэлгийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар 2003
2. Болдбаатар. Ш, Нутгийн иргэдэд түшиглэсэн гамшгийн эрсдэлийн менежмент, гарын авлага, 2010
3. Дэлхийн банкны “шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх төсөл”ийн Боом өвчний голомтын судалгаа төслийн тайлан Улаанбаатар хот 2014
4. ДЭМБ-ын зөвлөмж
5. ЗӨСҮТ Зоонозын халдварт өвчний 2019 оны нөхцөл байдлын мэдээлэл,
6. ЗӨСҮТ-ийн жилийн үйл ажиллагааны тайлан 2015-2019 он
7. Монгол Улсын Шадар сайдын 125 дугаар тушаал
8. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба дотоод хэргийн их сургуулийн хууль сахиулахуй онол, арга зүйн улирал тутамын сэтгүүл 2020 №02\24\ ¹ О.Үржин ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗҮЙН АСУУДАЛ 2020, Улаанбаатар
9. Хёогогийн үйл ажиллагааны хүрээ /2005-2015/ баримт бичиг
10. Хөвсгөл аймгийн ЗӨСТ-ийн 2020 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан
11. Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийн байдал 2020/12 эмхэтгэл, 2021, Мөрөн
12. Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын Хөвсгөл аймгийн нэгдсэн дүн /Хураангуй/ Улаанбаатар, 2020
13. Эрүүл мэндийн сайдын 2002 оны 166 тоот тушаалын нэгдүгээр хавсралт тарваган тахал өвчинтэй тэмцэх арга хэмжээний заавар
14. Mongolian Journal of Agricultural Sciences [Vol 29 No 1 \(2020\)](#) ISSN 2310-6212 eISSN 2524-0722 Н. Норов*, Б. Лхам, Ц. Батболд, О. Хурцбаатар, З. Түвшинзаяа, Н. Энхцэцэг, Ж. Энхтуяа Хөвсгөл аймгийн боомын голомтын мэдээлэл 2017
15. https://nczd.gov.mn/?page_id=2458